



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн “Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-ын бүтээгдэхүүнийг бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Нэйшнл лайф даатгал” ХХК /Г.Монголхүү/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Нэйшнл лайф даатгал” ХХК /Г.Монголхүү/-д анхааруулсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны ᠒᠘ дүгээр сарын ᠒8-ны өдрийн  
155 дугаар тогтоолын хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Нэйшнл лайф даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Эрүүл мэндийн даатгал
4.	Даатгалын зүйл	Даатгуулагчийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой ашиг сонирхол
5.	Даатгалын эрсдэл	-Даатгуулагч даатгалын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Ковид-19 вирусаар өвчилсний улмаас амь насаа алдах; -Даатгуулагч даатгалын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Ковид-19 вирусаар өвчилсний улмаас хөдөлмөрийн чадвараа алдах
6.	Даатгалын гэрээний хугацаа	2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 00:00 цаг хүртэл
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	13 бүлэг, 68 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/31 дүгээр тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Актуарч Б.Балжинноров
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Б.Хулан